

“АХМАДЫН САН БАЙГУУЛАН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДРИЙН
243 ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТ.



ХОЛБООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА,
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ Б.САРАНТУЯА

2025 ОНЫ 06 САРЫН 06
УЛААНБААТАР ХОТ

АХМАД НАСТНЫ ТУХАЙ (ШИНЭЧЛЭН НАЙРУУЛСАН) ХУУЛЬ
2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 01-НЭЭС МӨРДӨГДӨЖ ЭХЭЛСЭН.

“АХМАДЫН САН БАЙГУУЛАН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ”
ЗАСГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ 197-Р ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОН.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДРИЙН
243 ДУГААР ТОГТООЛЫН ХОЁРДУГААР ХАВСРАЛТААР БАТЛАГДСАН
“АХМАДЫН САН БАЙГУУЛАН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ” ХЭРЭГЖИЖ
ЭХЛЭВ.

“АХМАДЫН САН БАЙГУУЛАН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ
ЖУРАМ” ШИНЭЭР БАТЛАГДСАНТАЙ
ХОЛБОГДУУЛАН ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ
ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ 83 ДУГААР ТОГТООЛООР
БАТЛАГДСАН “ШҮҮХИЙН АХМАДЫН САНГИЙН
АЖИЛЛАХ ЖУРАМ”-ЫГ ӨӨРЧЛӨХӨӨР АЖИЛЛАЖ
БАЙНА.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ 243 ДУГААР ТОГТООЛЫН
ХОЁРДУГААР ХАВСРАЛТААР БАТЛАГДСАН “АХМАДЫН САН
БАЙГУУЛАХ АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ” НЬ ИЛҮҮ ТОДОРХОЙ,
ХЭРЭГЛЭХЭД ХЯЛБАР, ОЙЛГОМЖТОЙ БОЛСОН.

ТУХАЙЛБАЛ: ТУС ЖУРМЫН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛИЙН 1.1-Д

“АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГААС
АХМАДЫН САНГ БАЙГУУЛАН АЖИЛЛУУЛАХ, САНГИЙН
ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ГҮЙЭТГЭЛИЙГ
ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХАД ЭНЭ ЖУРМЫГ БАРИМТАЛНА.”

ЖУРМЫН 1.3:

АХМАДЫН САНГИЙН ХӨРӨНГӨ НЬ ТУХАЙН БАЙГУУЛЛАГЫН
ТӨСВИЙН НЭГ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ БАЙНА.

ЖУРМЫН 1.4:

БАЙГУУЛЛАГА НЬ АХМАД НАСТНЫ ТООНООС
ХАМААРАН АХМАДЫН САНГ ЦАЛИНГИЙН САНГИЙН
ХЭДЭН ХУВИАР ТОГТООХ АСУУДЛЫГ ХОЁР ЖИЛД
НЭГ УДААБАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ АХМАДЫН
ХОРОО, ЗӨВЛӨЛТЭЙ ХЭЛЭЛЦЭН ТОГТООЖ, ТУХАЙН
БАЙГУУЛЛАГЫН НИЙТ АЖИЛТНЫ ХУРАЛД
ТАНИЛЦУУЛНА.

ЖУРМЫН 1.5:

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА АХМАДЫН САНГИЙН
ХӨРӨНГИЙГ ТӨРИЙН САНГИЙН ДАНСАНД
БАЙРШУУЛНА.

ЖУРМЫН ХОЁР ДАХЬ ХЭСЭГ ...АХМАДЫН
САНГИЙН ХӨРӨНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ... ХЭСГИЙН
2.1.1:

“...ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА ТУХАЙН ЖИЛИЙН
ТӨСӨВТ ТУСГАН ЦАЛИНГИЙН НИЙТ САНГИЙН
ГУРАВ ХҮРТЭЛХ ХУВЬТАЙ ТЭНЦЭХ
ХЭМЖЭЭГЭЭР АХМАДЫН САНД ТӨВЛӨРҮҮЛСЭН
ХӨРӨНГӨ;

АХМАДЫН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

3.1 АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 12.1, 14.6-Д
ЗААСАН ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛНА:

3.1.1-3.1.10-Т ЗААСАН АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛНА
3.1.10 ...ХУУЛЬД ЗААСАН ХҮРЭЭНД АХМАД НАСТАНД
ЧИГЛЭСЭН БУСАД ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ
САНХҮҮЖҮҮЛЭХ. /ЭНЭ ЗААЛТ ШИНЭЭР НЭМЖ ОРСОН/

3.1.3 ...НИЙТИЙН ХАЛААЛТГҮЙ СУУЦ, ГЭРТ
АМЬДАРДАГ АХМАД НАСТАНД ТҮЛШ ХУДАЛДАН
АВАХАД ЗОРИУЛАН МӨНГӨН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ,

3.1.4 ...ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛЖ БАЙГАА АХМАД
НАСТАНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ,

3.1.5 .. ШИНЭЭР ХАШАА, БАЙШИН БАРИХ, ЗАСВАРЛАХ,
ОРОН СУУЦНЫХАА НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХАД
ЗОРИУЛЖ АХМАД НАСТАНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ;

3.1.6 ... ЭРҮҮЛ МЭНДИЙН ШАЛТГААНААР УДААН
ХУГАЦААГААР ӨВЧТЭЙ БАЙГАА АХМАД НАСТАНД
ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛД ЗОРИУЛЖ МӨНГӨН ТУСЛАМЖ
ҮЗҮҮЛЭХ;

3.1.7 ...АХМАД НАСТАН ӨӨРӨӨ ЭСХҮЛ, ТҮҮНИЙ
НӨХӨР (ЭХНЭР) НЬ НАС БАРСАН ТОХИОЛДОЛД
МӨНГӨН ТУСЛАМЖ ОЛГОХ;

3.1.8 ...АХМАДУУДЫН ДУНД ИДЭВХТЭЙ НАСЖИЛТЫГ
ДЭМЖИХ АМРАЛТ, АЯЛАЛ, УРЛАГ, СПОРТЫН АРГА
ХЭМЖЭЭ, УРАЛДААН ТЭМЦЭЭН ЗОХИОН
БАЙГУУЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ;

3.1.9 ...АМЬЖИРГААНЫ БАТАЛГААЖИХ ТҮВШИНГЭЭС
ДООГУУР ОРЛОГОТОЙ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ
БОЛОН ХАРЖ ХАНДАХ АХ ДҮҮ, ТӨРӨЛ САДАНГҮЙ,
ГАНЦ БИЕ АХМАД НАСТАНД МӨНГӨН ТУСЛАМЖ
ҮЗҮҮЛЭХ;

ЖУРМЫН 3.2:

.ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА АХМАДЫН САНГИЙН
ХӨРӨНГӨӨР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ
ШИЙДВЭРЛЭХГҮЙ.

ЖУРМЫН3.3:

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ ЭНЭ ЖУРМЫН 3.1.3, 3.1.9-д ЗААСАН МӨНГӨН ДЭМЖЛЭГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООЖ, ДОТООД ЖУРАМ, АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭНЭ.

ЖУРМЫН 3.5:

АХМАДЫН САНГААС ДЭМЖЛЭГ, ТУСЛАМЖ
АВАХЫГ ХҮССЭН АХМАД НАСТАН ТУХАЙН
БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ АХМАДЫН ХОРОО
ЗӨВЛӨЛД ХҮСЭЛТ ГАРГАНА.

ЭНЭ ЖУРМЫН 3.5-Д ЗААСАН ХҮСЭЛТИЙГ ТУХАЙН
БАЙГУУЛЛАГЫН АХМАДЫН ХОРОО, ЗӨВЛӨЛИЙН АЛБАН
ЁСНЫ САНАЛЫГ ҮНДЭСЛЭН АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН
ШУУД ЗАХИРА

ЖУРМЫН 3.10:

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА НЬ АХМАДЫН САНД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙГ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН
ФИСКАЛ ПРОГРАММЫН "АХМАДЫН САН" ГЭСЭН
ЗОРИУЛАЛТАД ТУСГАН БАТЛУУЛЖ, ТУХАЙН
БАЙГУУЛЛАГЫН АХМАДЫН САНД ШИЛЖҮҮЛЖ,
ХОЛБОГДОХ ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛНЭ.

ЖУРМЫН 3.11:

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН АХМАДЫН САНД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙГ ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 42.3-Т
ЗААСНЫ ДАГУУ ТӨСӨВТӨӨ ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ
САНАЛ ГАРГАЖ, ШИЙДВЭРЛҮҮЛНЭ.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

